

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
/2023 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар/

2023 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Зүйл заалтын дэс дугаар	Биелэлт	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
<i>Нэг . Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол</i>					
1	“Алдарт эх”-ийн одонгоор шагнуулах эхчүүдийг уламжлах тухай 2023.03.15 №01 Дүүргийн харьяат олон хүүхэд төрүүлж, өсгөн “Алдарт эх” I зэргийн одонгийн болзол хангасан эхчүүдийн нэрсийг нэгдүгээр, “Алдарт эх” II зэргийн одонгийн болзол хангасан эхчүүдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.	2.Хавсралтад нэр дурдсан эхчүүдийг “Алдарт эх” I, II зэргийн одонгоор шагнуулахаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсугай. 3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Олон хүүхэд төрүүлж өсгөн, Алдарт эх 1,2 дугаар зэргийн одонгоор шагнуулах болзол хангасан Чингэлтэй дүүргийн харьяат нийт 421 эхийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлав. Болзол хангасан 417 эхчүүд 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр хуваарийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчөөс одонгоо гардан авч, 4 одонг дүүргийн удирдлагууд хүлээлгэн өглөө.	100	
2	Төрийн цол, одон медалиар шагнуулахаар уламжлах тухай 2023.03.15 №02 2023.04.28 №10 2023.07.07 №13 2023.11.01 №17	Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнуулах болзол хангаж, байгууллага, хамт олноос тодорхойлж, ирүүлсэн дараах иргэдийг дэмжиж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсугай.	Төрийн дээд цол, одон, медалиар шагнуулахаар байгууллага, хамт олноосоо тодорхойлгдож ирсэн Чингэлтэй дүүргийн харьяат 768 иргэний тодорхойлолт, материалыг хүлээн авч, хэлэлцэн дэмжиж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлав.	100	

1	2	3	4	5	6
3	“Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023.04.14 №03 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай” тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлд дараах заалтуудыг нэмж тусгасугай.	2.Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж, хэрэгжилтийг зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д даалгасугай. 3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст бүртгүүлэх хүсэлтээ 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр гаргасан боловч тус газар нь татварын өр төлбөртэй, өр барагдуулах хугацаатай үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаагүй гэх шалтгаанаар дүрмийн өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсан байна.	100	
4	Чингэлтэй дүүргийн “Хүүхдийн номын өргөө” төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газрын нэрийг өөрчилж, дүрмийг шинэчлэн батлах тухай 2023.04.14 №04 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн “Хүүхдийн номын өргөө” төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газрын нэрийг “Чингэлтэй дүүргийн хүүхэд хөгжлийн цогцолбор” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулж, дүрмийг	2.“Чингэлтэй дүүргийн хүүхэд хөгжлийн цогцолбор” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын шинэчилсэн дүрмийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, төсөвт үйлдвэрийн газрын бүтэц орон тоог шинэчлэн баталж, үйл ажиллагааны зардлыг дүүргийн жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэхийг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д даалгасугай. 4.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн	“Чингэлтэй дүүргийн хүүхэд хөгжлийн цогцолбор” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын шинэчилсэн дүрмийг 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж, дүүргийн Засаг даргын 2023 оны Б/72 дугаар тушаалаар тус газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлуулсан. Тус газрын төсвийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 28 дугаар тогтоолд 377.5 сая төгрөгийг тусган батлуулсан бөгөөд төсвийг батлагдсан сар, хуваарийн дагуу олгож байна.	100	

1	2	3	4	5	6
	хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.	Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.			
5	Хамгаалалтын бүсийн хилийн цэсийн солбицлыг шинэчлэн тогтоох тухай 2023.04.14 №05 Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан Чингэлтэй хайрхан уулын салбар уулс болох Шадивлан, Яргайт, Яргайтын богино, Гүнт, Жигжид, Майхан толгой, Ойн булаг орчмын хамгаалалтын бүсийн хилийн цэсийн солбицлыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.	2.Шинэчлэн тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн цэсийн солбицлыг газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д үүрэг болгосугай. 4.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Шинэчлэн тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн цэсийн солбицлыг газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх хүсэлтээ 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 2/994 тоот албан бичгээр Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлсэн. Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дугаар хэсэгт заасны дагуу уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн талаар албан бичиг ирүүлснийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлж, ажиллалаа.	100	
6	Хамтарсан баг байгуулах тухай 2023.04.14 №06 Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хороодод гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгааллын үйлчилгээг хамтран үзүүлэх чиг үүрэг бүхий хамтарсан багийг хавсралт ёсоор байгуулсугай.	2.Хамтарсан багийг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Батсүмбэрэл)-д даалгасугай. 3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Дүүргийн 1-24 дүгээр хороодод 2023 оны 3/1005 дугаар албан бичгээр Хамтарсан баг байгуулах тухай чиглэлийг хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Дүүргийн 5 хорооны Хамтарсан багийн 25 гишүүдийг “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд 11 багц модуль 3 удаагийн 4 өдрийн сургалтад хамруулж чадавхжууллаа. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хороодын хамтарсан багийн гишүүдийн хуулийн мэдлэгийг дээшлүүлэх, кейс менежментийг үр дүнтэй үзүүлэх чадавхыг сайжруулах, шилдэг хамтарсан багийг шалгаруулж, сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор удирдамж батлуулсан,	100	

1	2	3	4	5	6
			зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллаж байна.		
7	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2023.04.14 №07	1.Дүүргийн 2023 оны төсөв батлах тухай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 28 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг нэгдүгээр, гуравдугаар хавсралтаар баталсан Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022-2023 он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус өөрчлөн баталсугай.	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй.	-	
8	Хурлын Зөвлөл байгуулах тухай 2023.04.14 №08 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж, хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн олонхын санал авсан дараах нэр бүхий Төлөөлөгчдийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүнээр сонгож, баталсугай.	2.Хууль тогтоомж, холбогдох журмын хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлж, идэвх санаачилгатай ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай. 3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийг 7 Төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан бөгөөд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, тайлант хугацаанд өргөн барьсан асуудлын хүрээнд 5 удаа хуралдаж, 5 тогтоол шийдвэрийг баталж, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллаж байна.	100	
9	Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл байгуулах тухай 2023.04.28	2.Холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангаж	Тус хурлын тогтоолыг үндэслэн Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийг хороо бүрд байгуулах чиглэлийг 2023 оны 3/1106 тоот албан бичгээр хороод болон дүүргийн	100	

1	2	3	4	5	6
	№09 1.Төрийн үйлчилгээний тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, иргэдийн санал хүсэлт, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд дүүргийн зорилтот бүлгийн иргэнийг нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэх талаар шийдвэр гаргах, халамжийн үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийг хороо бүрд хавсралт ёсоор байгуулсугай.	ажиллахыг Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлд даалгасугай. 3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал”-аар нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэхээр 1607 өрхөөс судалгаа авсан байна. Дүүргийн 1-24 дүгээр хороодын Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн: -Асаргааны мөнгөн тэтгэмжийг 2577 иргэнд 1,369,991.217₮ -Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 833 иргэнд 176,420,592₮ -Онцгой тохиолдлын тэтгэмжийг 26 иргэнд 31,200,000₮ -Тэжээгчээ алдсаны тэтгэвэрийг 703 иргэнд 1,011,529,222₮ тус тус олгосон байна. Мөн Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох амьдрах ухаанд сургах зорилгоор төслийн шалгаруулалт зарласан бөгөөд 31 төсөл ирүүлснээс 27 төслийг шалгаруулж, 58,865,000₮, өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмжийг 287 иргэнд 315,047,892 төгрөгийг тус тус олгосон байна.		
10	Дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай 2023.07.07 №12		Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй.	-	

11	Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 2023.07.07 №14	Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.	Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг чиг үүрэг бүхий 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав.	100	
12	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн бэлгэдлийг батлах тухай 2023.07.07 №15	1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн бэлгэдлийн тодорхойлолт, эх загварыг хавсралт ёсоор баталсугай.	Дүүргийн бэлгэдлийг хэрэглээнд нэвтрүүлж, интернэтийн хайлтын системээс өмнөх бэлгэдлийг устгуулан шинэ бэлгэдлийг байршуулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх байгууллагуудад тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг тус тус хүргүүлэн ажилласан.	70	
13	Дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай 2023.11.01 №16		Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй.	-	

ХУРЛЫН АЖЛЫН АЛБА